



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/143

Бат-Өлзий сум

**Шууд гэрээ байгуулах тухай**


Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын хэсгийн 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Хурдан морины хашаа барих, сэрвээ хэмжилтийн талбайн хашаа барих ажлыг 5 дугаар багийн иргэн Доржсүрэнгийн Авирмэдтэй шууд худалдан авах гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2. Иргэн Д.Авирмэдтэй гэрээ байгуулж, хашаа барих ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Хурдан морины хашаа барих, сэрвээ хэмжилтийн талбайн хашаа барих ажилд шаардагдах 14,500,000 (арван дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийг гэрээнд заасны дагуу Орон нутгийн төсвийн бусад хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН